

**ОЧИР-УНДРАА ХХК-ИЙН ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-012415 ТООТ
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ
ЗООЛУУ ХАР-ЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АГУУЛГА

ОРШИЛ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	1-1
1.1 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ	1-1
1.2 ТӨСЛИЙН БАЙРШИЛ.....	1-1
1.3 ТӨСЛИЙН ЗОРИЛГО	1-2
1.4 ОРДЫН НӨӨЦ.....	1-2
1.5 Ил уурхайн ашиглалтын систем, тоног төхөөрөмж	1-2
1.6 Ажиллах горим.....	1-3
1.7 ЭЛС УГААН БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИ.....	1-3
1.7.1 Элс угаан баяжуулах цехийн хаягдлын сан	1-3
1.8 УУРХАЙН ДЭД БҮТЭЦ	1-4
1.9 ХОГ ХАЯГДАЛ.....	1-5
1.10 ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦОО	1-5
БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	2-6
3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ.....	2-8
3.2 ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	2-8
3.3 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	2-8
3.4 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	2-8
3.5 ХОГ ХАЯГДЛЫН УЛМААС ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ.....	2-9
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-10
4.1 ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	4-10
4.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ	4-10
4.3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	4-10
4.4 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-15
4.5 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	Error! Bookmark not defined.
4.6 НҮҮЛГЭН СУУРЬШУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	4-16
4.7 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-16
4.8 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-17
4.9 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4-17
4.10 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4-20
4.11 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	4-22
4.12 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-26
4.13 БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-27

ДҮГНЭЛТ 4-28

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1-1. MV-012415 тоот тусгай зөвшөөрлийн талбайн солбицол	1-1
Хүснэгт 1-2. Уурхайд хэрэглэгдэх тоног төхөөрөмж.....	1-2
Хүснэгт 4-1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4-11
Хүснэгт 4-2. Ногоон байгууламжийн төлөвлөгөө	4-15
Хүснэгт 4-3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	4-16
Хүснэгт 4-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	4-18
Хүснэгт 4-5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	4-21
Хүснэгт 4-6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	4-23
Хүснэгт 4-7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	4-26
Хүснэгт 4-8. БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах хуваарь.....	4-27

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-1. Төслийн байршил	1-1
Зураг 1-2. Алт агуулсан элсийг угаан баяжуулах технологийн схем	1-3
Зураг 1-3. Элс угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмж болон усан хангамжийн зураг	1-4



Зураг 4-1. Мод тарих байрлал.....	4-15
Зураг 4-2. Дүйцүүлэн хамгаалах боломжит газрууд	4-16

ОРШИЛ

Очир-Ундраа ХХК нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын 2 дугаар багийн нутагт байрлах Зоолуу хар-ын алтны шороон ордын 190 га талбайн ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2007.04.18-ний өдөр авсан байна. Анх 2015 онд БОННУ тайлан хийлгэсэн бөгөөд 2016-2017 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын нөөцийн тооцооны тодотгол тайлан дахь ордын нийт бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр шлихээр 274.12 кг, химийн цэврээр 242.34 кг-аар тооцон Ашигт малтмал газрын тосны даргын 2019.03.15-ны өдрийн Н/27 дугаар тушаалаар нөөцийг хүлээн авч, бүртгэсэн байна.

Дээрх нөөцөд тулгуурлан ордын ТЭЗҮ-ийн тодотгол тооцоог 2020 онд явуулж, уурхайн ашиглалтын 2 жилийн хугацаанд 233.14 мян.м³ элс олборлон баяжуулахаар ТЭЗҮ-ийг боловсруулсан байна. Улмаар ТЭЗҮ шинэчлэгдэж 2022 онд БОННУ нэмэлт тодотголыг Баялаг эко ХХК-иар хийлгэсэн байна.

Тус компани нь 2017 оноос хойш Зоолуу хар-ын алтны шороон ордод үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд 2022 оноос үйл ажиллагаагаа эхлүүлэхээр төлөвлөж, энэхүү 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд, БОАЖЯ-ын 2022.04.06-ны өдрийн 13/1540 тоот байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт, Баялаг эко ХХК-ийн боловсруулсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн нэмэлт тодотгол болон БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 2,3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу боловсруулав.

2023 оны БОМТ-ний хүрээнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор нийт 35,000,000 төгрөг зарцуулан 43 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөв.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.1 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ


Төслийн нэр	Зоолуу хар-ын алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл
Төсөл хэрэгжүүлэгч	<ul style="list-style-type: none"> ✓ Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Очир-Ундраа ХХК ✓ Улсын бүртгэлийн дугаар: 9011122089 ✓ Регистрийн дугаар: 2659603 ✓ Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай 8/1, Сити Тауэр бизнес төв, 17 давхарт ✓ Утас: +976-75757979, +976-11-326466 ✓ Цахим шуудан: ganzorig.ba@ochir-undraa.mn

1.2 ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Очир-Ундраа ХХК-ийн Зоолуу хар-ын алтны шороон ордын MV-012415 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт Зоолуу хар нэртэй газар Улаанбаатар хотоос 220 орчим км, Дархан-Уул аймгаас зүүн урагш 50 км, Хонгор сумаас зүүн урагшаа 45 км, Шарын гол сумаас баруун хойшоо 7 орчим км-т байрлана. Ордын талбайн хэмжээ 190 га бөгөөд уурхайн солбицлын цэгийг Хүснэгт 1-1-д, төслийн байршлыг Зураг 1-1-т тусгав.

Хүснэгт 1-1. MV-012415 тоот тусгай зөвшөөрлийн талбайн солбицол

№	Уртраг	Өргөрөг
1.	106°24'41.21"	49°17'18.41"
2.	106°24'41.21"	49°17'48.91"
3.	106°23'1.21"	49°17'48.91"
4.	106°23'1.21"	49°17'18.41"



Зураг 1-1. Төслийн байршил

1.3 ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-012415 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Зоолуу хар-ын алтны шороон ордын талбайд хими цэврээр 242.34 кг алт байгаад тулгуурлан уг ордыг 2 жилийн хугацаанд 233.14 мян.м³ элс олборлон баяжуулж, 217.2 кг алт олборлон ордыг аж ахуйн эргэлтэд оруулж улс орны төсөвт өөрийн хувь нэмрээ оруулж, шинээр ажлын байр бий болгон, уул уурхайн салбарыг хөгжүүлнэ.

1.4 ОРДЫН НӨӨЦ

Зоолуу хар-ын алтны шороон ордын нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн ХХ-15-08 дугаар дүгнэлт болон Ашигт малтмал газрын тосны даргын 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн Н/27 тоот тушаалаар хүлээн авч, нөөцийг Ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн байна. 2016-2017 онд Очир Ундраа ХХК-ийн геологичдын хийсэн хайгуулын ажлын нөөцийн тодотгол тайлангийн үр дүнгээр ордын нөөц бодитой В зэрэглэлээр шлихээр 270.49 кг, химийн цэврээр 239.12 кг, боломжтой зэрэглэлээр шлихээр 6.63 кг, химийн цэврээр 3.22 кг, ордын хэмжээнд нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр шлихээр 274.12 кг, химийн цэврээр 242.34 кг-аар тооцоолсон байна. Уурхайн ашиглалтын эхний жилд хими цэврээр 75.09 кг, хоёр дахь жилд 164.83 кг бүтээгдэхүүн гаргах хүчин чадал бүхий төслийг 2 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

1.5 ИЛ УУРХАЙН АШИГЛАЛТЫН СИСТЕМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Зоолуу хар-ын алтны шороон ордын ашиглалтын гүн их биш, уул-геологийн нөхцөл харьцангуй энгийн тул ил уурхайг гадаад болон дотоод овоолго бүхий авто тээвэртэй ашиглалтын системээр элсийг скруббер -хоригт цоргын хослолоор угаан, баяжуулах ширээгээр гүйцээн баяжуулахаар байна.

Уурхай нь дараах процессоор явагдана. Үүнд:

- Үржил шимт өнгөн хөрс хуулах
- Хөрс хуулах
- Элс олборлох
- Элс угаан баяжуулах
- Хөрсний дотоод овоолго үүсгэх түүнийг тэгшлэх
- Техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх зэрэг багтана.

Уурхайд хэрэглэгдэх тоног төхөөрөмжийг Хүснэгт 1-2-д тусгав.

Хүснэгт 1-2. Уурхайд хэрэглэгдэх тоног төхөөрөмж

№	Техник, тоног төхөөрөж	Тоо хэмжээ (ш)	Марк
1.	Экскаватор	3	Doosan S500LCV
2.	Автосамосвал	8	MT-76
3.	Утгуурт ачигч	1	XG951
4.	Угаах төхөөрөмж	1	СБ-80
5.	Бульдозер	3	SD-32
6.	Усны шахуурга	2	140TSPA
7.	Усны шахуурга	2	ЭЦВ-8-40-40
8.	Усны шүүрүүлэх насос	1	WQG-100-35-18.5
9.	Үйлчилгээний машин	1	Istana /микро/
10.	Үйлчилгээний машин	1	ланд 80
11.	Түлшний машин	1	3тн
12.	Усны машин	1	MT-76 /ёмкост/

Экскаватор, Автосамосвал, Бульдозер, Утгуурт ачигчийг уурхайн ухаж ачих, овоолго хийх, тээвэрлэх бүх процессуудад ашиглана.

1.6 АЖИЛЛАХ ГОРИМ


Уурхайн ажиллах горим нь улирлын шинж чанар, цаг агаар, уур амьсгал, ил уурхайн жилийн хүчин чадал зэргээс шалтгаална. Уурхай эхний жилд 7 дугаар сарын 1-ээс эхлэн 123 хоног, хоёр дахь жилд 03 дүгээр сараас бэлтгэл ажлыг эхлүүлэн 199 хоног ажиллахаар тооцоолсон байна.

Ажиллах хүч. Уурхайн ажиллагааг тасралтгүй явуулахын тулд нийт 93 хүн 12 цагаар, 2 ээлжээр ажиллана.

1.7 ЭЛС УГААН БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИ

Очир-Ундраа ХХК нь 2017 онд Ханлаб ХХК-ийн боловсруулсан технологи туршилтын тайлангийн үр дүнд үндэслэн элсийг скруббер-хоригт цоргоны хослолоор угаан баяжуулах, баяжуулах ширээгээр гүйцээн баяжуулах схемийг сонгосон байна. Элс угаах тоног төхөөрөмжийн хувьд хүндийн хүчээр ангилан ялгах скруббер болон хоригт цоргоны хослол болох 1 ширхэг СБ-80 маркийн скруббер, гүйцээн баяжуулалтад баяжуулах ширээ гэсэн үндсэн тоног төхөөрөмжийг ашиглана.

Элсний том ангилалд байгаа наалдцыг усаар угаан шигшиж ангилсны дараа алт агуулсан нарийн ширхэгтэй ангиллыг хоригт цоргоор баяжуулан алттай шлихыг ялгаж авна. Угаах төхөөрөмжөөс ялгасан шлихын баяжмалыг гүйцээн боловсруулах цехэд боловсруулна. Гүйцээн ялгалтыг баяжуулах ширээгээр баяжуулах ба дараа нь соронзонгоор хар шлихыг ялгаж цахилгаан зуухан дээр хатааж, тороор шигшин ангилж, ангилал тус бүрийг үлээн ялгана.




Зураг 1-2. Алт агуулсан элсийг угаан баяжуулах технологийн схем

1.7.1 ЭЛС УГААН БАЯЖУУЛАХ ЦЕХИЙН ХАЯГДЛЫН САН

Элс угаан баяжуулах цехийн хаягдлын санг ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дотор, уурхайн зүүн талд өмнө олборлолт явуулж дууссан хоосон орон зайг ашиглан байгуулахаар төлөвлөсөн байна. Хаягдлын санд хаягдах булингар өөрийн жингээр тунах ба ялгарсан ус өөрийн урсгалаар эргэлтийн усан сан руу орно. Эргэлтийн усан санд тунасан усыг насосоор угаах төхөөрөмжид шахаж өгнө.

Баяжуулах цехийн хаягдал нь 20 мм-ээс дээш ширхэглэлтэй галь, 20 мм-ээс доош ширхэглэлтэй эфель байна. Төслийн нийт хугацаанд 42.4 мян.м³ галь, 190.76 мян.м³ эфель байна. Эдгээр хаягдлуудыг нийлүүлж олборлолт явуулсан ил уурхайн орон зайг дүүргэх замаар

техникийн нөхөн сэргээлтэд ашиглана. Эфелээс ялгарсан усыг урьдчилан бэлтгэсэн нуурын тусламжтайгаар тунгааж цэвэршүүлээд эргэлтийн усаар ашиглана.



Зураг 1-3. Элс угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмж болон усан хангамжийн зураг

Зургийн тайлбар: 1-Анхдагч элсний овоолго, 2-Утгуурт ачигч, 3-Скруббер, 4-Гаалийн овоолго 5-Хоригт цорго, 7-Баяжуулах ширээ, 8-Гүйцээн баяжуулах өрөө, 9-Технологийн усны насос 10-Эргэлтийн усан сан, 11-Тунаах далан, 12-Бульдозер, 13-Цэвэр усны сан, 14-Цэвэр усны насос

1.8 УУРХАЙН ДЭД БҮТЭЦ

Цахилгаан хангамж: Зоолуу хар-ын алтны шороон ордын цахилгааны хэрэглээг хангах зорилгоор 2015 онд ЦДҮСүлжээ ХК-ийн Төвийн бүсийн салбарын Шарын гол суманд байрлах 110/6 кВ-ын дэд станцаас Шарын голын уурхайн амралт уруу татсан 6 кВ-ын шугамаас салбарлуулан 6.4 км урт 6 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг 100, 160, 400 кВт дэд станцуудын хамт өөрийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулсан байна.

Барилга байгууламж. Очир-Ундраа ХХК-ийн Зоолуу хар-ын алтны шороон орд нь дараах байгууламжаас бүрдэнэ. Үүнд:

- Уурхайн хотхон.
- Контор. 20*15 хэмжээтэй сендвичен барилга байна.
- Тээврийн хэрэгсэл зорчих зам гүүр
- Түлшний агуулах.50 тн багтаамжтай.
- Цэвэр усны нуур, бохир усны нуур
- Шатахуун түгээх станц.
- Засварын цех. 20*30 хэмжээтэй сендвичен барилга байх бөгөөд 24 цагийн харуул хамгаалалттай.

Усан хангамж: Зоолуу хар-ын алтны шороон ордын унд ахуй болон технологийн усыг талбайд өрөмдсөн худаг болон уурхайн шүүрлийн усаар хангана. Төслийн талбайд гаргасан худгийн ундарга нь 4.2 м, гүн нь 50.0 м байна. Уурхайн унд ахуй болон хэрэглээний усыг хангах зорилгоор ЭЦВ-8-40-40 маркийн 2 ш насос ашиглана. Угаан баяжуулах хэсгийн хажууд цэвэр

болон бохир усны нуурыг байгуулах ба далан нуураас угаах төхөөрөмж рүү цагт 140 м³-ийн хүчин чадалтай 140TSPA маркийн 2 ш шахуурга хэрэглэхээр сонгосон байна.

Элс угаах тоног төхөөрөмжийн хувьд хүндийн хүчээр ангилан ялгах скруббер болон хоригт цоргоны хослол болох 1 ширхэг СБ-80 маркийн скруббер, гүйцээн баяжуулалтанд баяжуулах ширээ гэсэн үндсэн тоног төхөөрөмжийг ашиглана.

Харин уурхайн шүүрлийн болон хур тунадас, үерийн улмаас орж ирэх болзошгүй ус зайлуулахад WQG-100-35-18.5 маркийн 1 ш шүүрүүлэх насос байхаар тус тус сонгосон байна.

1.9 ХОГ ХАЯГДАЛ

Хатуу хог хаягдал: Зоолуу хар-ын алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагааны явцад уурхайн ажилчдын хэрэглээнээс хатуу хог хаягдал гарна. Хатуу хог хаягдлыг дараах байдлаар тооцов. Уурхайн ашиглалтын жилд нэгэн зэрэг 60 орчим ажиллах учраас хог хаягдлын тооцоог 60 хүнээр тооцоолов. Нэг хүн өдөрт 0.5 кг хатуу хог хаягдал гаргана тооцоолоход хоногт 30 кг, уурхайн ашиглалтын эхний жилд 3690 кг, хоёр дахь жилд 5970 кг хатуу хог хаягдал үүсэхээр байна.

Шингэн хог хаягдал: Төслийн үйл ажиллагааны явцад ажилчдын ахуйн хэрэглээ, уурхайн хотхон, элс угаан баяжуулах цехээс шингэн хаягдал гарна. Нэг хүний усны хэрэглээний нормыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 7 сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаал Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормын 12 дугаар хавсралтын Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон байр, ус халаагууртай, усанд орох онгоцтой орон сууц төрлөөр тооцон хоногт ахуйн хэрэгцээнд 20 литр ус хэрэглэнэ гэж тооцоолоход хоногт 60 хүн 1200 л ус буюу 1.2 м³ ус хэрэглэхээр байна. Үүний 70%-ийг ахуйн шингэн хаягдал болно гэж тооцвол хоногт дунджаар 840 л буюу 0.84 м³ жилд 0.588 м³ (жилд 167.16 м³) шингэн хаягдал гарахаар байна.

Очир-Ундраа ХХК нь өмнө уурхайд ашиглаж байсан бохирын сиптек танкийг хэрэглэн шингэн хаягдлыг зайлуулна.

Аюултай хог хаягдал: Уурхайн үйл ажиллагаанд хэрэглэгдэх экскаватор 5, автосамосвал 8, утгуурт ачигч 1, угаах төхөөрөмж 1, бульдозер 3, усны машин 1 ш хэрэглэх бөгөөд тэдгээр техник тоног төхөөрөмжийн ашиглалтаас гарсан дугуй, тоормосны шингэн, түлшний тос, түлш хийсэн хуванцар сав зэрэг нь уурхайн үйл ажиллагааны түршид гарна. Иймд үүссэн аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад нийлүүлж, устгуулах шаардлагатай.

1.10 ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦОО

Төслийн ашиглалтын хугацаанд нийт 8170.48 сая.төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай ба бэлэн мөнгөний эргэлтээрээ 1.2 дах жилдээ анхны хөрөнгө оруулалтын зардлаа нөхөх юм. Олборлох үйл ажиллагааны эхний жилд 68 кг алт борлуулах ба 2427.7 мян.м³ уулын ажил, хоёр дахь жилд 149.2 кг алт борлуулах ба 3115.01 мян.м³ уулын ажил хийгдэнэ. Нийтдээ 30.41 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 15.19 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардал гарах юм. ААНОАТатварт эхний жилд 431.7 сая.төг, хоёр дах жилд 4497 сая.төг төлөхөөр байна.

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Физик газарзүй: Уурхай нь физик газарзүйн мужлалын ангиллаар Хангайн уулт их мужид хамаарна. Хангайн уулт их муж нь Хангайн өндөр уулын муж, Орхон-Туул-ын сав газрын бэсрэг уулсын муж гэсэн 2 мужид хуваагдана. Хангайн өндөр уулын муж нь 185,314.3 км², талбайн хэмжээгээр нутаг дэвсгэрийн 11.8 %, Орхон-Туул-ын сав газрын бэсрэг уулсын муж 102,216.1 км², талбайн хэмжээгээр 6.5 хувийг тус тус эзэлнэ. Уурхайн талбай нь Хэнтийн уулархаг мужийн баруун хойд салбар уулсын хүрээнд Шарын голын районд харьяалагдана. Гадаргуугийн хамгийн нам цэг нь Шарын голын хөндийд 790 м, хамгийн өндөр цэг нь талбайн урд хэсэгт орших Их Дархан уул 1242.3 м хүрэх бөгөөд харьцангуй өндөржилт нь 50-600 м-ийн хооронд хэлбэлзэнэ.

Уур амьсгал: Дархан-Уул аймаг нь халуун, дулааны ба хүйтний улирал гэсэн эрс тэс уур амьсгалтай бөгөөд Монгол орны газар тариалангийн гол бүс нутаг юм. Уг бүс нутагт VII сарын дундаж агаарын температур нь +17- (+20)°C, хоногийн дундаж агаарын температур +10 градусын заагийг хавар V сарын сүүлч, намар IX сарын дунд үед тус тус дайрч, энэ үеийн үргэлжлэх хугацаа нь 111-120 хоног, уулархаг хэсэгтээ 105-110 хоног байдаг. Энэ хугацаанд 1750-2250°C-ын нийлбэр дулаан хуримтлагддаг. Хаврын цочир хүйтрэл олон жилийн дунджаар V сарын 25- аас VI сарын эхээр шувтарч, намрын анхны цочир хүйтрэл VIII сарын сүүлч, IX сарын эхээр тохиолддог. Жилд унах хур тунадасны хэмжээ дунджаар 280 мм байна.

Гадаргын ус: Дархан-Уул аймгийн Хонгор сум нь ус зүйн мужлалаар Хойд мөсөн далайн ай савд багтах бөгөөд бүхэлдээ Хараа голын сав газрын нутаг юм. Хойд мөсөн далайн ай сав нь Монгол орны нутаг дэвсгэрийн 20.6 хувийг эзэлдэг бөгөөд манай орны хамгийн их устай Сэлэнгэ мөрөн цутгал голуудынхаа хамт, Енисей болон Хар эрчис мөрнүүдийн эх болох Шишхид, Хүрэмтэй голууд хамаарагдана. Сэлэнгэ мөрөнд манай орны томоохон голууд болох Орхон, Туул, Хараа, Ерөө голууд цутгадаг. Энэ ай савд хамаарагдах гол мөрний нийт урт 35000 км орчим байдаг. Төслийн талбай нь Шарын голоос дээш 7.5 км зайд байрладаг. Голын усны түвшин 850.0 м байна. Уурхайн ордын хэсэгт газрын гадаргуугийн үнэмлэхүй өндөр 900-960 м буюу Шарын голын усны төвшнөөс 50-110 м өндөрт байгаа бөгөөд уг орд нь Шарын голтой ямар нэг гидравлик холбоо байхгүй. Хөндийн гадаргуу нь голын зүг бага зэрэг налуу хэлбэртэй. Гадаргуугийн уснаас (шар усны, борооны) алтны давхарга нь ус үл нэвтрүүлэгч улаан өнгийн шаврын үеэр тусгаарлагдсан байдаг. Хайгуулын ажлын явцад цооногуудад усны 2 үе илэрсэн. Уст давхарга нь 16.0-32.0 м-т байрлах ба усны ундарга нь 2.4-4.6 л/сек байна.

Газрын доорх ус: Уурхай нь Хараа голын сав газарт хамаарна. Тус сав газар нь зүүн талаараа Хэнтийн нурууны ноён оргил Асралт Хайрхан (Ү.Ө 2800 м), Гунын нуруу(Ү.Ө 1950 м), Барууны чулуут (Ү.Ө 2800 м), Оорцогын гозгор (Ү.Ө 1876 м), Түнхэлийн хөх байцын нуруу, Мөнгөлөг нуруу зэрэг хэд хэдэн намавтар уул, нуруудыг дамжсан ус хагалбараар Орхон голын сав газартай тус тус хиллэж байна. Хараа голын сав газрын хэмжээнд Голоцений настай аллювийн хурдас, Плейстоцений настай пролювийн хурдас, Юра, Триас, Пермийн настай давхраадаст тунамал чулуулаг, тектоник хагарал, өгөршлийн ан цавд эрчимтэй өртөгдсөн өөр өөр насны түрмэл, бялхмал, хувирмал чулуулгууд тархсан бөгөөд эдгээр хурдас, чулуулаг нь нүх сүвийн болон ан цавын газрын доорх ус агуулсан байна.

Хөрсөн бүрхэвч: Зоолуу хар-ын алтны шороон орд орчмын бүс нутагт хар хүрэн хөрсний дэд хэв шинжүүдэд багтах глейрхэг хар хүрэн ба ердийн хар хүрэн төрлийн хөрснүүд тархсан байна. Эдгээр хөрснөөс төрлийн хувьд ердийн хар хүрэн хөрс талбайн 90% орчимд зонхилон тархана. Ердийн хар хүрэн хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин дунд зэрэг буюу ялзмагийн агууламж нь 2-5%, зузаан үе давхаргатай, шороон зам зэрэг техникийн нөлөөтэй эвдрэл талхагдалд дунд зэрэг тэсвэртэй, эргэж нөхөн сэргэхдээ мөн дунд зэрэг байна. Төслийн талбайн зүүн урд хэсэгт

хийсэн хөрсний зүсэлт, зүүнээс баруун тийш чиглэсэн 2-3 градус налуутай тэгшивтэр байрлах ба газрын гадарга нь шороон замаар бага зэрэг талхлагдсан, голлох ургамлын бүлгэмдэл нь хялгана-алаг өвст, хөрсний гадарга дээр чулууны бүрхэц байхгүй, давсжилт ба намагжилт байхгүй, хөрсний доройтол байхгүй, ил хог хаягдлын бохирдол байхгүй байна. Хөрсний үе давхаргууд нь: А (0-25 см), АВ (25-56 см), В (56-70 см) гүнтэй байна. Төслийн талбайн хэмжээнд нөлөөлөлд өртөөгүй буюу эвдэрч талхлагдаагүй 120.4 га, ердийн шороон зам, шимт хөрсний овоолго, хотхонийн талбай зэрэгт өртөж өнгөн хөрс нь бага зэрэг талхлагдсан 11.8 га, хамгаалалтын шуудуу далан, уурхайн технологийн зам талбай зэрэгт өртөж дунд зэрэг эвдэрсэн 13.9 га, уурхайн карьер ба замын хайрганы карьер зэрэгт өртөж хүчтэй эвдэрсэн 44 га талбай тус тус байна.

Ургамлан нөмрөг: Уурхай нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Монгол Дагуурын ойт хээрийн тойрогт хамаарна. Монгол-Дагуурын ойт хээрийн тойрог нь Хэнтийн нурууны захын салбар уулсыг хамрах бөгөөд Хэнтийн тойргийг тал цагариг байдлаар хүрээлэн оршино. Хэнтийн нурууг тойрсон Онон, Улз, Түүл, Хараа, Ерөөгийн хөндийн зурвас нутгийг хамаарна. Ургамлын аймгийн хувьд уулархаг хээрийн ургамал зонхилно. Тус тойрогт нийт 1307 зүйл тархсан ба зөвхөн энэ тойрогт тохиолдох 50 зүйл ургамал ургана. Төслийн талбайд биелэг-алаг өвс ба биелэг – улалж- алаг өвс зонхилно. Харин Хонгор сумын нутагт зонхилон хялгана- үетэн алаг өвст, хялгана- алаг өвст, зүр өвс – үетэнт эвшлүүд нь нам уулсын орой хажуугаар тохиолдох бөгөөд ухаа гүвээт долгиорхог тал хээрт хялгана үетэн – алаг өвст, хялгана - хиаг–алаг өвст, хялгана-хиаг–үетэнт, хялгана-харганат эвшлүүд зонхилно.

Амьтны аймаг: Амьтны аймгийн газарзүйн мужлалаар (А.Г.Банников, 1954) Монгол орны хойд хэсэг Тайгын мужид багтах ба бусад хэсэг нь Монгол Төвөдийн мужид багтана. Харин Тайгын муж дотор дэд мужийг ялгахгүйгээр Хөвсгөл орчмын ба Хэнтийн гэсэн 2 тойрог болгож хуваасан байна. Уг мужлалаар төслийн талбай нь Хэнтийн тойрогт багтана. Хэнтийн тойрогт ойн хүрэн оготно, ойн улаан оготно, ойн хулгана, асганы огдой, хэрэм, жирх, чандага, буга, бөр гөрөөс, хандгай, гахай, хүдэр, махан идэшт амьтдаас цагаан үен, ойн солонго, булга зэрэг амьтад зонхилно.

Тусгай хамгаалалттай газар нутаг: Уурхайн 190 га талбай нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай ямар нэгэн давхцалгүй байна.

Нийгэм, эдийн засаг: 2021 оны байдлаар Дархан-Уул аймагт 29512 өрхийн 104,737 хүн суурьшиж байгаагаас Хонгор суманд 1587 өрхийн 5964 хүн, 2-р багт 489 өрхийн 1874 хүн суурьшиж байна. Дархан-Уул аймаг нь цахилгаан дулаан эрчим хүч үйлдвэрлэл, цэвэр ус, нүүрс, алт, төмрийн хүдэр, элс хайрга, шохойн чулуу, тоосго, хөнгөн бетон, шохой, бетон зуурмаг, баяжуулсан хүдрийн болон хүнсний төрөл бүрийн үйлдвэрлэл, мах бэлтгэн боловсруулах, оёдол, арьс боловсруулах, нэхий бүтээгдэхүүн, эсгий шаахай, вакум буюу хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл зэргийг голлон үйлдвэрлэж байна. Тус аймагт аж үйлдвэрийн 3 салбарын 19 дэд салбарын нийт 233 цэг нэгж үйлдвэрлэл эрхлэн зах зээлд нийлүүлж байгаагаас үүл уурхайн олборлох аж үйлдвэрийн салбарт 19, боловсруулах салбарт 203, цахилгаан дулааны эрчим хүчний салбарт 11 нэгж үйлдвэрлэл эрхлэн 203 гаруй нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Зоолуу хар-ын алтны шороон ордыг ашиглах төсөл амжилттай хэрэгжсэнээр Дархан-Уул аймгийн Хонгор сумын нийгэм эдийн засагт эергээр нөлөөлөхөөр байна.



БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Уурхайн агаар бохирдуулагч эх үүсвэр нь уурхайн тээврийн зам, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт, овоолго үүсгэх, тээврийн хэрэгслийн түлшний шаталт, Уурхайн ухашаас элс ачих болон хөрсний овоолго дээр хөрс буулгахад үүсэх тоосжилт, Тээврийн хэрэгсэл болон тоног төхөөрөмжийн түлшний шаталтаас агаар бохирдуулагч бодис агаарт ялгарна.

- Уурхайн ашиглалтын 2 жилд дотоод хөрс тээврийн замаас агаарт нийт 552.83 тн тоосжилт үүсэх
- Уурхайн дотоод элс тээврийн замаас агаарт 0.435 тн $PM_{2.5}$, 4.34 тн PM_{10} тоосонцор үүсэх
- Тээврийн хэрэгслийн зарцуулах түлшний шаталтаас бохирдуулагч бодис ялгарах
- Уурхайн ашиглалтын 2 жилд нийт 233.14 мян.м³ элс олборлон баяжуулах бөгөөд эхний жилд 87.95 мян.м³, хоёр дахь жилд 145.2 мян.м³ элс олборлоно. Алт агуулсан элсийг олборлон ухаж ачих, тээвэрлэх, овоолгод хураах зэрэг үйл ажиллагаанаас тоосжилт үүсэх

3.2 ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний үед гарсан шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний сав баглаа боодол, техник хэрэгслийн сэлбэг (аккумулятор, хаягдал дугуй, олгой)-ийн хаягдлыг ил задгай хаясан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдох
- Уурхайн ашиглалтын 2 жилд нийт уулын ажилд хамрагдах болон эвдрэлд орох 27.96 га талбайн хөрсөн бүрхэвч хэв шинжээ алдах
- Уурхайн ашиглалтын жилд нийт 5309.53 мян.м³ хөрс хуулах ба эхний жилд 2339.7 мян.м³, хоёр дахь жилд 2969.82 мян.м³ хөрс хуулалтын явцад ухаж ачих, тээвэрлэх, овоолгод байршуулах зэрэг үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвч эвдрэх
- Уурхайн ажилчдаас гарах ахуйн хог хаягдлыг зориулалтын саванд хадгалаагүй болон тогтмол төвлөрсөн хог хаягдлын цэг рүү зөөвөрлөөгүйн улмаас хөрс бохирдох

3.3 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Ажилчдын үнд ахуйд хоногт 1.2 м³ (жилд 238.8 м³) ус хэрэглэж хоногт 0.84 м³ (жилд 167.16 м³) шингэн хаягдал үүсэх
- Технологид 2 дахь жилд хамгийн их ус хэрэглэх хамгийн их 145.2 мян.м³ элс олборлож угаан баяжуулахад нийт 581,760.0 м³ ус ашиглах
- Зам талбайн усалгаанд хоногт 96 м³ (672 м³) ус, биологийн нөхөн сэргээлтэд хоногт 2 дахь жилд 535,200 м² талбайд хоногт 305.8 м³ (жилд) 12,843.6 м³ ус ашиглах

3.4 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Олборлолтын ажлын үед хөрс хуулалтын улмаас нийт 70.2 га талбай эвдрэлд орж, ургамлан нөмрөг устгах
- Шимт хөрсний овоолго ачилт буулгалтын үед үүссэн тоос ургамлан нөмрөгийн гадаргуу дээр тогтож ургамлын бүтээмжийг бууруулах
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс гарах тоос, утаа, олон төрлийн хүнд элементүүд тухайн орчныхоо 15-50 м зай доторх ургамлан нөмрөгийн идэвхтэй фотосинтезийн үйл ажиллагааг бууруулах
- Уурхайн орчмын амьтдын амьдрах орчин алдагдах, амьдрах орчноос үргэж, дайжих



- Олборлолтын улмаас үүссэн үхмал нүх, тунаах болон цэвэршүүлэх нуурыг стандарт журмын дагуу нөхөн сэргээхгүй орхисон тохиолдолд мал, хүн амьтан унаж эрсдэх

3.5 ХОГ ХАЯГДЛЫН УЛМААС ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Элс угаан баяжуулах үйлдвэрийн хаягдал нь уурхайн 2 жилийн хугацаанд 42.4 мян.м³ галь, 190.76 мян.м³ эфель байна.
- Ахуйн хатуу хог хаягдал хоногт 30 кг, жилд 5970 кг, шингэн хог хаягдал хоногт = 0.84 м³, жилд 167.16 м³ ус ашиглах
- Аюултай хог хаягдал нь уурхайн шатах тослох материалын сав баглаа боодол, асгаралтаас үүссэн цэвэрлэгээний материал, машин механизмыг засварлах үйл ажиллагаанаас гарах хаягдлууд үүсэж болзошгүй байна.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

Очир-Ундраа ХХК нь байгаль хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж, уурхайн ашиглалтын жилд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлсэн бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3-т заасан хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн мөн хуулийн 9.10-т зааснаар хуримтлагдсан хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу буцаан олгохоор зохицуулагдсан байна.

Очир-Ундраа ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан БОАЖЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батлуулах үүрэгтэй.

4.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны 2021.04.06-ны өдрийн 13/1540 тоот байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт, 2022 оны байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол болон БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журамд заасан шаардлагуудын дагуу хийж гүйцэтгэсэн ба 2023 онд нийт **35,000,000 ₮** зарцуулахаар төлөвлөв.

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал (төг)	
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3,100,000	
2.	Байгаль	Ногоон байгууламжийн төлөвлөгөө	2,800,000
3.	орчныг	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	12,500,000
4.	хамгаалах	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	ХАБ-д тусгагдсан
5.	төлөвлөгөө	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	9,000,000
6.	Орчны хяналт	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал
7.	шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	7,600,000
Нийт зардал		35,000,000	

4.3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОННУ-ээр тогтоосон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, бууруулах, арилгах, тэдгээрийн үр дагаврыг хянах арга хэмжээний төлөвлөгөөг боловсрууллаа.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг Хүснэгт 4-1-д тусгав.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.₮	Тоо хэмжээ	Нийт зардал (сая.₮)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
Агаарын чанар									
1.	Хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөр сул шороо үүсэж, тоосжилт ихсэж агаарын чанарт нөлөөлөх	Уурхайд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслийг үзлэгт хамруулж, засвар үйлчилгээг хийх	Уурхайн 28 ш техник тоног төхөөрөмж	-	Үйл ажиллагааны зардалд тусгах		Хуваарьт үзлэг болон жил бүрийн улсын тээврийн хэрэгслийн үзлэг	MNS:4598:2020. Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага	
2.		Тээвэрлэлтийн үед хурдны хязгаарт хяналт тавих (ачих, буулгах хэсэгт 20 км/ц, технологийн замд 40 км/ц байх г.м) тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	Уурхайн тээврийн зам	ш	Тэмдэг - 10,000 Самбар- 50,000	10 тэмдэг, 2 самбар	ХАБ-ийн зардал	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	MNS:5013:2009. Бензин хөдөлгүүртэй автомашин – утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
3.	Хөрс хуулалтын явцад ухаж ачих, тээвэрлэх, овоолгод байршуулах зэрэг үйл ажиллагаанаас тоосжилт үүсэх	Уурхайн дотоод тээврийн замыг услах	Уурхайн дотоод тээврийн зам	Удаа	Уурхайн шүүрлийн усаар услах	20	Уурхайн шүүрлийн усаар услах	Сард 4 удаа (5-9 сар)	БОННУ тайлангийн 4.1-т тусгаснаар -Эрүүл ахуйн тухай хууль
		Уурхайн орчны 50 м хүртэлх талбай	Уурхайн гадаад тээврийн зам						
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч									
4.	Олборлолтын явцад нөлөөлөлд өртөөгүй талбайн хөрс хуулагдаж, хэв шинжээ алдах	Уурхайн олборлолт, хөрсний гадаад овоолго зэрэгт өртөх талбайн үржил шимт хөрсийг урьдчилан 50-60 см-ийн	Уурхайн олборлолтын талбай	м ³	-	эхний жилд 2339.7 мян.м ³	-	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	MNS:4596:2014. Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.₮	Тоо хэмжээ	Нийт зардал (сая.₮)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
		зузаантайгаар хуулж, хадгалах							хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм;
5.	Машин техникийн шатах тослох материал, нефтийн бүтээгдэхүүн асгарч хөрсөн бүрхэвч бохирдох	Засварын цех, ШТС-ын талбайг хатуу хучилттай болгох, техникийн эвдрэл гэмтлийг зориулалтын талбай (засварын цех)-д байрлуулж засах	Засварын цех, ШТС	м ²	Үйл ажиллагааны зардалд тусгах			Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	MNS 4919:2000. Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага БОННУ тайлангийн 4.2-т тусгаснаар
6.	Хөрсний бохирдол	Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалж, сумын нэгдсэн хогийн цэг рүү тээвэрлэх	Уурхайн хотхон, гал тогоо	удаа	50.0	Гэрээнд тусгаснаар	1.2	7 хоногт 1 удаа (жилд 24 удаа)	
7.	Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрсөн бүрхэвч бохирдох	Асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг яаралтай авах, саармагжуулах хэрэгслийг бэлэн байлгах	Засварын газар, ШТС	ш			Үйл ажиллагааны зардалд тусгах	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
8.	Шингэн хаягдлаар хөрс бохирдох	Ахуйн бохир ус цэвэрлэх бага оврын цэвэрлэх байгууламж байгуулах	Уурхайн хотхон	ш		Үйл ажиллагааны зардалд тусгах		Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
Усан орчин									
9.	Газрын доорх усыг хэт их ашигласнаар гүний	Усыг гамтай хэрэглэх талаар ухуулга, сурталчилгааг	Уурхайн хотхон, мэдээллийн самбар	-	150.0	4	ХАБ зардал	Улиралд 1 удаа	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6.1.2

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.₮	Тоо хэмжээ	Нийт зардал (сая.₮)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	усны нөөц хомсдох	мэдээллийн самбарт байрлуулах							-Усны тухай хууль -Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журмын 2.6
10.	Ундны усны чанар алдагдах	Ундны усны эх үүсвэр бохирдохоос сэргийлж, худгийг хашаалах	Уурхайн худаг	м ²	Үйл ажиллагааны зардалд тусгах			Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
11.	Уурхайн үйл ажиллагааны улмаас газрын доорх усны түвшин буурах	Ус ашиглах гэрээ байгуулж, ус ашиглалтын төлбөрийг гэрээний дагуу тооцож, тогтоосон хугацаанд нь төлөх	Уурхайн худаг	Ашигласан усны хэмжээнээс хамааруулан үйл ажиллагааны зардалд тусгах				Жил бүр	
12.	Ил уурхайн гүн доошлохын хэрээр усны шүүрэлт ихсэж, уурхайгаас зайлуулах усны хэмжээ нэмэгдэх	Уурхайн олборлолтоос үүсэх шүүрлийн усыг шавхах дамжуулах хоолойн эд ангийг тогтмол шалгах, төлөвлөгөөт засваруудыг хийх	Уурхайн олборлолтын хэсэг	удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах			Сард 1 удаа	
Ургамлан нөмрөг									
13.	Уулын ажлын төлөвлөгөөгөөр хөндөгдөх газрын ургамлан нөмрөг устгах	Уурхайн уулын ажлын төлөвлөлтийн дагуу газар ашиглах, хөндөх талбайд ургамлан бүрхэвчийн мэдээллийн сан, бүртгэлийн систем бий болгох	Уурхайн олборлолтын хэсэг			1,500,000		Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	-Байгалийн ургамлын тухай хууль -Ургамал хамгааллын тухай хууль

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.₮	Тоо хэмжээ	Нийт зардал (сая.₮)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
14.	Уурхайн үйл ажиллагаагаар ойр орчмын ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх	Олон наст ургамал тарьж зүлэгжүүлэх, мод тарих ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хийж гүйцэтгэх	Уурхайн ногоон байгууламж байгуулах талбай	ш	Ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгав.				
Амьтны аймаг									
15.	Уурхайн тээвэрлэлтийн улмаас олон салаа замүүд үүсэж амьтад дайруулах	Уурхайн замын дагуу ан амьтдын анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Уурхайн дотоод болон гадаад зам	-	400	10	0.4	Жилийн турш	-Амьтны тухай хууль -Ан агнуурын тухай хууль
Нийт					3,100,000 ₮				

4.4 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зоолуу хар-ын алтны шороон ордыг 2 жилийн хугацаанд ашиглах бөгөөд 2023 онд 5 га Биологийн нөхөн сэргээлт хийж 10 га-д техникийн нөхөн сэргээлт хийгдэхээр төлөвлөж байна. **НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Ногоон байгууламж байгуулах боломжтой талбайнуудад уурхайн хотхон, олборлолтод өртөх талбайн ойр орчмын талбайг сонгон авч ашиглалтын эхний жилд тарих ургамлын суулгацыг авч, мэргэжлийн байгууллагаар суулгах шаардлагатай. Ногоон байгууламжийн төлөвлөгөөнд **2,800,000 төгрөг** зарцуулахаар төлөвлөв.



Зураг 4-1. Мод тарих байрлал

Зоолуу хар-ын алтны шороон ордыг ашиглах төслийн хүрээнд уурхайн ажилчдын тосгоны ногоон байгууламж, техникийн нөхөн сэргээлт хийсэн уурхайн талбайд зарим нэг наст болон олон наст ургамал тарих бөгөөд тухайн бүс нутгийн байгаль цаг уурын нөхцөлд ургах чадавхтай согоовор, ерхөг, царгас, нарс, хайлаасыг хольж тарих нь тохиромжтой байна.

Хүснэгт 4-2. Ногоон байгууламжийн төлөвлөгөө

№	Зорилт	Ногоон байгууламжийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа
1.	Тариалах үр, суулгац авах	Ерхөг, согоовор Нарс, Хайлаас	кг ш	15-20 100	20.0 5.0	300.0 500.0	5-р сарын эхний 10 хоногт
2.	Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа, тордлогоо хийх	Ерхөг, согоовор Харгана, хайлаас	м ² ш	Үйл ажиллагааны зардалд тусгах			Жилд 17-18 удаа
	Ажлын хөлс		хүн	2	1000.0	2000.0	10-р сарын эхний 10 хоногт
Нийт				2,800,000 төгрөг			

Усалгааны норм: Тухайн модны тарьж ургуулах гарын авлага болон Байгаль Орчин Ногоон Хөгжил Аялал Жуулчлалын Яамны (БОНХАЖЯ)-ны сайдын 2015.07.30 өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтаар баталсан Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд

зарцуулах усны норм-ын Навчит модонд ашиглагдах усны норм 1 ш модонд 25 л, цэцэрлэг, зүлэг ногоо услах нормын дагуу 1 м² талбайд 4 л ус зарцуулж усална.

Ногоон байгууламжийн төлөвлөгөөнд Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Дархан-Уул аймаг 2032 хүртэл 20 сая мод, Хонгор сум 1 сая мод тарих үйл ажиллагаанд орон нутагтай хамтран ажиллахаар төлөвлөж байна.

4.5 НҮҮЛГЭН СУУРЬШУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Очир-Ундраа ХХК-ийн Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дахь Зоолуу хар-ын алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, айл өрхүүд байхгүй учир нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй гэж үзлээ.

4.6 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөс зайлсхийх болон нөлөөллийг бууруулах боломжит арга хэмжээг хэрэгжүүлэхийн хамт үйл ажиллагаа эхлэхтэй зэрэгцэн зайлсхийх боломжгүй нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд 2023 онд Уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлдөх Замын компанийн өмнө эвдэгдсэн 2 га талбайг нөхөн сэргээхээр төлөвлөн ажиллаж байна. Уулын ажлын хүндрэлтэй уул техникийн нөхцөлөөс шалтгаалж тус эвдэгдэгдсэн 2га талбайгаас технологийн зориулалтаар дэвсгэлтийн материал авч ашиглана.

Зураг 4-2. Дүйцүүлэн хамгаалах боломжит газрууд

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд эхний жилд 12,500,000 төгрөг зарцуулахаар тооцов.

Хүснэгт 4-3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төрөл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт зардал (сая.төг)	Тайлбар
Биологийн олон янз байдлын суурь нөхцөл байдлыг үнэлэх судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Санал болгож буй дүйцүүлэн хамгаалахаар сонгосон ТХГН-т биологийн олон янз байдлын суурь судалгаа хийх суурь судалгаа, аюул заналын үнэлгээ хийж, биологийн олон янз байдлыг хамгаалах, аюул заналыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах		ДХ-аар санал болгож буй газарт одоогийн байдлаар амьтан, ургамлын
	Аюул заналын үнэлгээ хийж биологийн олон янз байдлыг хамгаалах, аюул заналыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах		талаарх судалгаа шинжилгээний ажил хомс байна.
Хонгор сумын бэлчээрийг сайжруулах	Орон нутагтай хамтран сумын отрын бүсийн бэлчээрийг хашиж, хамгаалах		Хонгор сумын нутаг нь бэлчээрийн хомсдол, доройтолд ихээр өртсөн байна.
Сумын газар нутагтай хамтран ажиллах	Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт	2.5	Нөхөн сэргээх бодлого баримталж байна.
	Тэрбум мод төслийн хүрээнд мод тарих	5.0	
	Байгаль орчны нөлөөл бууруулах	2.5	



Нийт	12,500,000 ₮
------	--------------

4.7 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн ашиглалтын талбай орчимд одоогоор археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. Гэвч уурхайн газар шорооны ажлын явцад соёлын өв олохыг үгүйсгэж болохгүй. Тиймээс уурхай үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

Хэрэв уурхай ашиглалтын явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах малтлага судалгааг хийлгэх нь зүйтэй.

4.8 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Очир-Ундраа ХХК нь БОННУ-ний эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон аюул ослоос урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах, арилгах талаарх хууль, дүрэм, журмын дагуу ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэн ажиллах нь зүйтэй. Уурхайн гэнэтийн ослын болон химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, ХАБЭА-н арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөв.

Хүснэгт 4-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн зардал, мян ₮	Тоо хэмжээ	Нийт зардал (1 жил) сая ₮	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	5	6	7	8	9	
<i>Байгалийн гамшигт үзэгдэл болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийн менежментийн төлөвлөгөө</i>								
1.	Байгалийн гамшигт үзэгдлүүд	Эрх бүхий байгууллагаар гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэх	Уурхайд			Үйл ажиллагааны зардалд тусгах	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	Гамшгаас хамгаалах тухай хууль
2.		ОБЕГ-ын мэдээ болон цаг агаарын станцын мэдээг тогтмол хянаж үйл ажиллагаанд харгалзан үзэж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, дохиог ажилчдад дамжуулан анхааруулга өгч байх	Ажилчид			Үйл ажиллагааны зардалд тусгах	Цаг уурын мэдээнд суурилах	MNS 6010:2009 Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт, ерөнхий анги MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 5390:2004 Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 4968:2000 Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих
3.	Гал түймэр	Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлж бэлэн байлгах, гал унтраах хэрэгслийн хэвийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт тогтмол хийх	Уурхайн хотхон, засварын газар, ШТС			Үйл ажиллагааны зардалд тусгах	Сард 1 удаа байрлуулсан гал унтраах хэрэгслийн хэвийн ажиллагааг шалгах	
4.		Галын аюулын талаар анхааруулга самбар, аваарын гарц, барилгын зохион байгуулалт зэргийг уурхайн объект бүрт байрлуулах	Уурхайн барилга байгууламж			Үйл ажиллагааны зардалд тусгах	Хуваарьт үзлэг хийх	
5.		Гал түймрийн үед авч хэрэгжүүлэх ажлын	Ажилчид			Үйл ажиллагааны	Жилд 1-2 удаа	

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн зардал, мян ₮	Тоо хэмжээ	Нийт зардал (1 жил) сая ₮	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
		төлөвлөгөөг гарган ажиллагсдад сургалт зохион байгуулах				зардалд тусгах		аргад тавих ерөнхий
6.	Үйл ажиллагааны осол гэмтэл	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Ажилчид	Үйл ажиллагааны зардалд тусгах			Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
7.		Бүх ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Ажилчид	Үйл ажиллагааны зардалд тусгах			Өдөр бүр	
		Нийт						



4.9 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Очир-Ундраа ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын хэмжээг багасгах, түүнийг дахин ашиглах, хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах шаардлагатай.

Энгийн хог хаягдал:

Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь дахин ашиглах (хуванцар, гялгар уут, цаас, картон, шил, лааз), хүнсний хаягдал, бусад дахин ашиглагдахгүй хог хаягдал гэж 3 төрлөөр ангилан ялгана.

- Дахин боловсруулах хог хаягдлыг орон нутгийн дахивар авдаг газартай гэрээ байгуулан хүргүүлэх
- Хүнсний хог хаягдлыг бордоо үйлдвэрлэдэг төсөл хөтөлбөр, байгууллагатай хамтран ажиллаж, хүнсний хог хаягдлаа өгөх, бордоо хийж түршин, ногоон байгууламжид ашиглах
- Бусад дахин боловсруулах боломжгүй хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тогтсон хугацаанд тээвэрлүүлнэ.

Аюултай хог хаягдал:

Машин техникийн шатах тослох материал, аккумулятор, хаягдал дугуй аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалан, аюултай хог хаягдал тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах, эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан устгуулна. Аюултай хог хаягдал түр хадгалах тусгай зориулалтын шаардлага хангасан цэг байгуулж, аюултай хог хаягдлыг хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн нэр, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх бөгөөд ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна. Уурхайн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд эхний жилд дунджаар төгрөг зарцуулахаар төсөвлөв.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг Хүснэгт 4-5-д тусгав.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян ₮	Тоо хэмжээ	Нийт зардал (1 жил) сая ₮	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1		2	3		5	6	7	8	9
1.	Ахуйн хог хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын хогийн савыг байрлуулах	Уурхайн объект	ш	2000.0	4	8.0	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	-Хог хаягдлын тухай хууль -Энгийн хог хаягдлыг ангилах,
2.		Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг Дархан-Уул аймгийн Хонгор сумын хог хаягдал дахин боловсруулах төвд нийлүүлэх		удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах		Улиралд 1 удаа	Дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага	
3.		Хог хаягдлыг ангилан ялгаж, Хонгор сумын ТҮК-тай гэрээ байгуулж, тээвэрлэх		удаа	Гэрээнд заасан үнээр		Сард 1 удаа	- Эрүүл ахуйн тухай хууль	
4.		Уурхайн 50 м хүртэлх талбай хог хаягдлын цэвэрлэх	Орчны 50 м	удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах		Улиралд 1 удаа		
5.	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлыг түсгайлсан талбай бэлдэж тэмдэг тэмдэглэгээ хийж түр хадгалах, Аюултай хог хаягдлыг ангилан ялгах, зориулалтын сав байрлуулах	Засварын цех, ШТС	удаа	1000.0	-	1.0	Улиралд 1 удаа	-Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
6.		Үүссэн аюултай хог хаягдлыг хог хаягдал цуглуулах тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх		удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах		Үйл ажиллагаа эхлэхээс өмнө		
Нийт			9,000,000 төгрөг						

4.10 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна.

Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон төслийг хэрэгжүүлэх явцад Очир-Ундраа ХХК-аас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайдын 2014 оны 04-дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасны дагуу байгалийн бүрдэл тус бүрээр энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

Төслийн хүрээнд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг дотоод хяналт шинжилгээ, гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээ, хамтын оролцоотой хяналт шинжилгээ гэсэн 3 хэлбэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөж нийт **8,100,000 төгрөг** зарцуулахаар төлөвлөв.

- **Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр:** Очир-Ундраа ХХК уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй үр дагавруудыг хянах, илрүүлэх зорилгоор уурхайн агаар, хөрс, усны шинжилгээг улиралд 1 удаа, ургамал амьтны судалгааг жилд 1 удаа байхаар хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх
- **Гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр:** Хөндлөнгийн хяналт шинжилгээний байгууллагаар орчны хяналт шинжилгээг жилд 1-2 удаа хийлгэх, дотоод хяналт шинжилгээтэй харьцуулах, дүгнэх
- **Хамтын оролцоотой хяналт шинжилгээний хөтөлбөр:** Орон нутгийн иргэдтэй хамтран уурхайн ойр орчмын малчдын ундаалдаг булгаас дээж цуглуулах, шинжилгээний хариуг тайлагнах



№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Нэгжийн зардал, (мян.₮)	Нийт зардал (сая. ₮)	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	
Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр							
1.	Агаарын чанар <ul style="list-style-type: none"> Орчны тоосжилт (PM_{2.5}, PM₁₀ TSP) Агаарын температур Харьцангуй чийг Гадаад болон дотоод орчны дуу чимээ 	Уурхайн ухаш, дотоод тээврийн зам, овоолго, уурхайн хотхон	4	Улиралд 1 удаа	350.0	350.0 * 4 удаа = 1.4	MNS 4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 3384:1982. Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага. MNS 4048:1988. Байгаль хамгаалал. Агаар мандал. Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга.
2.	Хөрсний хими болон физик <ul style="list-style-type: none"> Ялзмаг Урвалын орчин (pH) Карбонат, нитрат, фосфор, кали Давсжилт Механик бүрэлдэхүүн Эзлэхүүн, жин 	Хөрсний овоолгууд, уурхайн хотхон, тээвэрлэлтийн зам дагуу, засварын газар	4	Улиралд 1 удаа	1 дээж 60.0*4 цэг = 240.0	0.96	MNS:5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS: 6341:2012. Хөрсний чанар. Хөрсөнд эрүүл зүйн Нян судлалын шинжилгээ хийх арга MNS 2305-1995. Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам
3.	Усан орчин <ul style="list-style-type: none"> Ерөнхий хими физикийн шинжилгээ Урвалын орчин (pH) Цэвэрлэсэн бохир усны биологийн хэрэгцээт хүчилтөрөгч болон 	Уурхайн ашиглалтын худаг	1	Улиралд 1 удаа	70.0	0.28	MNS: ISO: 5667-11:2001. Усны чанар. Дээж авах. 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж. MNS 0900:2018. Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Нэгжийн зардал, (мян.₮)	Нийт зардал (сая. ₮)	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	химийн хэрэгцээт хүчилтөрөгч						
Дотоод хяналт шинжилгээний зардал					2,640,000 ₮		
Гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр							
	Агаарын чанар						
4.	<ul style="list-style-type: none"> Орчны тоосжилт (PM_{2.5}, PM₁₀ TSP) Агаарын температур Харьцангуй чийг Агаар бохирдуулагч хий (SO₂, NO₂,) Гадаад болон дотоод орчны дуу чимээ 	Уурхайн ухаш, дотоод тээврийн зам, хүдрийн овоолго, ажилчдын хотхон	4	Жилд 2 удаа	350.0	350.0 * 2 удаа = 0.7	MNS 4585:2017 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга
	Хөрсний хими болон физик						
5.	<ul style="list-style-type: none"> Ялзмаг Урвалын орчин (pH) Карбонат, нитрат, фосфор, кали Давсжилт Механик бүрэлдэхүүн Эзлэхүүн, жин Хүнд металл 	Хөрсний овоолгууд, баяжуулах үйлдвэр, хаягдлын сангийн ойр орчим,	4	Жилд 2 удаа	1 дээж 60.0*4 цэг = 240.0	0.48	MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам; MNS 3298-1991 Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд; MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ; Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох (MNS 3310:91)

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Нэгжийн зардал, (мян.₮)	Нийт зардал (сая. ₮)	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Усан орчин							
6.	<ul style="list-style-type: none"> Ерөнхий хими физикийн шинжилгээ Урвалын орчин (pH) Цэвэрлэсэн бохир усны биологийн хэрэгцээт хүчилтөрөгч болон химийн хэрэгцээт хүчилтөрөгч 	Уурхайн ашиглалтын худаг Ойр орчмын үст цэг	2	Жилд 2 удаа	70.0 * 2 цэг = 140.0	0.28	MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 6778 : 2019 Ундны ус. Хатуулаг тодорхойлох арга
Ургамлан нөмрөг							
7.	<ul style="list-style-type: none"> Ургамлын зүйлийн бүрдэл Ургамлан нөмрөгийн бүрхэц 	Орчны бохирдолд өртөж болзошгүй цэг болон алслагдсан цэгүүд	-	Жилд 1 удаа	1000.0	1.0	Мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу
Амьтдын аймаг							
8.	<ul style="list-style-type: none"> Амьтдын нүүдэл шилжилтийн мониторинг Амьтдын тоо толгой 	Төслийн талбай болон түүний ойролцоох үст цэг, мод бутлаг ургамал бүхий талбайд	3	Жилд 1 удаа	1000.0	1.0	
Ажлын хөлс, унааны зардал					1,500,000		
Хөндлөнгийн хяналт мониторингийн нийт зардал					4,960,000 ₮		
Хамтын оролцоотой хяналт шинжилгээний хөтөлбөр							
9.	Орон нутгийн иргэдтэй хамтран дээж цуглуулах, шинжилгээний хариуг тайлагнах, мониторинг хийх			Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.			
Нийт хяналт мониторингийн зардал					7,600,000 ₮		

4.11 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Очир-Ундраа ХХК нь тухайн жилийн батлуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлыг гүйцэтгэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.10-т тусгаснаар байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, биелэлтийг жил бүр тайлагнана.

Хүснэгт 4-7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв сая ₮	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2022 он				
			Сар 4	Сар 8	Сар 12		
1	2	3	4	5	6	7	
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр бодлого, журам боловсруулж мөрдөх	Уурхайн дотоод төлөвлөлт өөр	Жилийн турш			Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	Байгаль орчны талаарх баримт бичиг
2.	Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 10 ¹ дүгээр зүйлд заасны дагуу Байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх	ҮАЗ*	Дотоод төлөвлөлтөөр (2 жилд 1 удаа)			Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	
3.	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх	ҮАЗ*	5 жилд 1 удаа				
4.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	ҮАЗ*		+	+	ХАБЭА ажилтан	Аюулгүй ажиллагааны дүрэм
5.	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хөдөлмөр хамгааллын нэг бүрийн хэрэгслээр хангах	ҮАЗ*	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө			ХАБЭА ажилтан	-
6.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн биелэлтийн тайланг Дархан-Уул аймгийн Хонгор сумын ЗДТГ-т хүргүүлэх	ҮАЗ			+	Байгаль орчны ажилтан	Байгаль орчны хууль тогтоомж

*Тайлбар: ҮАЗ – Үйл ажиллагааны зардалд тусгах

4.12 БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Очир-Ундраа ХХК нь жил бүрийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайланг хүргүүлэх ба төсөл хэрэгжих аймгийн байгаль орчны газар, сумын Засаг даргын тамгын газарт тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт 4-8. БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	6	7	
1.	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын яам	Тайлангийн эх хувь болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн	11 дүгээр сарын 01-ээс өмнө	Удирдлага болон Байгаль орчны мэргэжилтэн	Улаанбаатар хот
2.	Дархан-Уул аймгийн байгаль орчны газар		түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	11 дүгээр сарын 01-ээс өмнө		Дархан-Уул аймаг
3.	Хонгор сумын Засаг даргын тамгын газарт					Дархан-Уул аймгийн Хонгор сум

ДҮГНЭЛТ

Очир-Ундраа ХХК-ийн Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших MV-02415 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Зоолуу хар-ын алтны шороон ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан дараах дүгнэлтийг хийж байна.

- Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэрт орших MV-012415 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 190 га талбайг хамарна. Техник эдийн засгийн урьдчилсан тооцоогоор ордыг 2 жил ашиглаж, 233.14 мян.м³ элс олборлон баяжуулна.
- 2023 оны БОМТ-ний хүрээнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд 3.1 сая, ногоон байгууламжийн төлөвлөгөөнд 2.8 сая, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөнд 12.5 сая, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд 9.0 сая, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 7.6 сая төгрөгийг тус тус төлөвлөв.
- Очир-Ундраа ХХК нь 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд **35,000,000** төгрөг зарцуулан ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын буюу одоогийнхоор БОАЖЯ-ны нөхөн сэргээлтийн тусгай дансанд 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ.



“ОЧИР УНДРАА” ХХК-д

ДАРХАН-УУЛ АЙМАГ ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг, Дархан сум, 14-р баг
Монгол банкны II-давхар
Утас: 7037-3456, Факс: 7037-3456
И-мэйл: daboajg@gmail.com

2023. 04. 03. № 112
танай _____-ны № _____-т

Хамтран ажиллах тухай

Байгалийн нөөц баялгийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээх, технологийн хяналт тавих, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тодорхойлох, үнэлгээ дүгнэлт гаргах ажлын хэсгийн 2022 оны хурлаар үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан, төлөвлөгөөг хэлэлцсэн.

Тус ажлын хэсгийн хурлын шийдвэрийн дагуу 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэг хэсэг болох дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөндөө “Ногоон Дархан-2032” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хонгор сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Зулзагын голын нарсан ойн ойжуулалтын ажилд 20,000,000 төгрөгийг төсөвлөн оролцож, хамтран ажиллана уу.

ДАРГА

Г.БАТБАЯР



Тоот 2203290

Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр: "Очир-Ундраа" ХХК Дархан-Уул аймгийн Хонгор сумын 2-р баг
 Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-012415 тоот тусгай зөвшөөрөл бүхий "Зоолуу хар"-ын алтны шороон орд
 Огноо: 2023.01.13

№	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Авсан байвал зохих оноо	Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо							Гишүүдийн үнэлсэн онооны энгийн арифметик дундаж	Үндэслэл, тайлбар
			Гишүүн 1	Гишүүн 2	Гишүүн 3	Гишүүн 4	Гишүүн 5	Гишүүн 6	Гишүүн 7		
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20	12	14	15	10	10	10	12	12.1	
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт /техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлт, татан буулгах, хаалтад бэлтгэх/	30	30	30	30	30	30	30	30	30	
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10	9	9	9	9	9	9	9	10	
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт	5	0	0	0	0	0	0	0	0	5
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	10	9	9	10	10	10	10	10	10	10
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5
10	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5
	Нийт оноо	100	92	94	95	90	90	90	92	92.1	

Ажлын хэсгийн дарга:
Дархан-Уул аймгийн БОАЖГ-ын дарга

Гишүүд:

Ус цаг уур, орчны шинжилгээний
төвийн УОШХэлтэсийн дарга

Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын Экологийн асуудал
хариуцсан, эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч

БОАЖГ-ын Усны нөөц ашиглалт, хамгаалалт, төрийн бус байгууллага,
судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн

БОАЖГ-ын Орчны бохирдол, хог хаягдал,
химийн хорт бодис хариуцсан мэргэжилтэн

БОАЖГ-ын Газар, газрын хэвлий, тусгай хамгаалалттай
газар нутаг, БОНБҮнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Хүлээн зөвшөөрсөн:
"Очир-Ундраа" ХХК-ийн Гүйцэтгэх захирал


(Г. Батбаяр)


(М.Алимаа)


(Б.Должин)


(Б.Зам)


(Я.Батбилэг)


(А.Аззаяа)


(Д.Баянмөнх)


(Г. Мөнхзул)